



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А-167

Улаанбаатар хот

Ц.Болорчулуун нарыг томилолтоор
ажиллуулах, зардал гаргах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.8 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсэг, Сангийн сайдын 2011 оны "Гадаад томилолтын зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 188 дугаар тушаал, Петербургийн олон улсын эдийн засгийн чуулга уулзалтын урилга, Бүгд Найрамдах Беларусь Улсын Хөдөө аж ахуй, хүнсний сайдын 2021 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 06-1-2/609 урилгыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гадаад харилцааны сайд Б.Батцэцэгийн Оросын Холбооны Улсад хийх албан ёсны айлчлалын бүрэлдэхүүнд орж ажиллан, Газар тариалангийн техникийн шинэчлэл хөтөлбөрийн 3 дугаар үе шатыг хэрэгжүүлэх чиглэлээр ОХУ-ын Аж үйлдвэр худалдааны яамны төлөөлөлтэй уулзалт хийх, Петербургийн олон улсын эдийн засгийн чуулга уулзалтын хүрээнд зохион байгуулагдах Жижиг, дунд үйлдвэрлэлийн форумд оролцох, "Монгол Улсад Сүүний чиглэлийн эрчимжсэн цогцолбор аж ахуй байгуулах төсөл", "Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл" ийн асуудлаар Бүгд Найрамдах Беларусь Улсын Хөдөө аж ахуйн яам, "Минскийн тракторын үйлдвэр"-ийн төлөөлөгчидтэй уулзалт хэлэлцээ хийх ажлаар Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн Э.Өнө-Ундрах нарыг 2021 оны 05 дугаар сарын 30-наас 06 дугаар сарын 07-ны өдрүүдэд албан томилолтоор ажиллуулсугай.

2. Томилолтын удирдамжийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

3. Төлөөлөгчдийн албан томилолтоор ажиллахтай холбогдох зардлын төсвийг 2 дугаар хавсралтын дагуу 14,951,275 /Арван дөрвөн сая есөн зуун тавин нэгэн мянга хоёр зуун далан тав/ төгрөгөөр баталж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А-21 дүгээр тушаалын Хөдөө аж ахуй, газар тариалан, аж үйлдвэрийн судалгаа шинжилгээ хөтөлбөрийн 8.02-д заасан арга хэмжээнээс санхүүжүүлэхийг Ерөнхий нягтлан бодогч /Б.Отгонцэцэг/-д зөвшөөрсүгэй.

4. Томилолтоор ажилласан талаар буцаж ирснээс хойш ажлын таван өдөрт багтаан танилцуулахыг Бодлого, төлөвлөлтийн газрын Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн /Э.Өнө – Ундрах/-д даалгасугай.

ДАРГА



Т.ЖАМБАЛЦЭРЭН

00000639

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн яамны Төрийн нарийн
бичгийн даргын 2021 оны 65 дугаар
сарын 29-ны өдрийн А.167 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

ТОМИЛОЛТЫН УДИРДАМЖ

Тов: 2021 оны 5 дугаар сарын 30-наас 6 дугаар сарын 7-ний өдрүүдэд

Төлөөлөгчдийн бүрэлдэхүүн:

- Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун
- Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн мэргэжилтэн Э.Өнө-Ундрах

Зорилго:

Гадаад харилцааны Сайд Б.Батцэцэгийн ОХУ-д хийх албан ёсны айлчлалын бүрэлдэхүүнд орж ажиллан, Газар тариалангийн техникийн шинэчлэл хөтөлбөрийн 3 дугаар үе шатыг хэрэгжүүлэх чиглэлээр ОХУ-ын Аж үйлдвэр худалдааны яамны төлөөлөлтэй уулзалт хийх, Петербургын олон улсын эдийн засгийн чуулга уулзалтад оролцох, "Монгол Улсад Сүүний чиглэлийн эрчимжсэн цогцолбор аж ахуй байгуулах төсөл", "Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл"- ийн асуудлаар Бүгд Найрамдах Беларусь Улсын Хөдөө аж ахуйн яам, "Минскийн тракторын үйлдэр"-ийн төлөөлөгчидтэй уулзалт хэлэлцээ хийх.

Баримтлах чиглэл:

- Гадаад харилцааны Сайд Б.Батцэцэгийн ОХУ-д хийх албан ёсны айлчлалын бүрэлдэхүүнд орж ажиллах;
- Газар тариалангийн техникийн шинэчлэл хөтөлбөрийн 3 дугаар үе шатыг хэрэгжүүлэх, Монгол Улсын баруун болон зүүн бүсэд 2 элеватор барих асуудлаар ОХУ-ын Аж үйлдвэр худалдааны яамны төлөөлөлтэй уулзалт хийх;
- Петербургийн олон улсын эдийн засгийн чуулга уулзалтын хүрээнд зохион байгуулагдах Жижиг, дунд үйлдвэрлэлийн форумд оролцох;
- "Монгол Улсад Сүүний чиглэлийн эрчимжсэн цогцолбор аж ахуй байгуулах төсөл"-ийн явцыг эрчимжүүлэх асуудлаар Бүгд Найрамдах Беларусь Улсын Хөдөө аж ахуйн яам, "Белстройцентр" инженерийн нэгдсэн үйлдвэртэй уулзалт хийх;
- Сүүний болон махны чиглэлийн эрчимжсэн цогцолбор аж ахуйтай танилцан туршлага судлах;
- "Хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл"- ийн хүрээнд Монгол Улсад нийлүүлэгдэх хөдөө аж ахуйн техник, тоног төхөөрөмжийг хүлээн авах ёслолын арга хэмжээнд оролцон, Минскийн тракторын үйлдвэр болон тоног төхөөрөмж үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдтэй уулзалт хийх;
- Бүгд Найрамдах Беларусь Улсын Минск хотноо зохион байгуулагдах "БелАгро-2021" олон улсын хөдөө аж ахуй үзэсгэлэнд оролцох,

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн
үйлдвэрийн яамны Төрийн нарийн
бичгийн даргын 2021 оны 05 дугаар
сарын 20-ны өдрийн 1167 дугаар
тушаалын 2 дугаар хавсралт

ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХТАЙ ХОЛБОГДОХ
ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Төсөвлөсөн
		төгрөг
1.	<u>Замын зардал:</u> <u>Онгоц:</u> Улаан-Удэ – Москва – Санкт-Петербург Минск - Москва -Улан-Удэ 2 хүн x 2,305,000 = 4,610,000төг <u>Вагон:</u> Санкт-Петербург – Минск 2хүн x 9000руб x 38.67 руб = 696,060	5,306,060 төг
2.	<u>Зочид буудал:</u> 2хүн x 150\$ x 7 хоног = 2100\$ x 2,849.61 = 5,984,181 төг	5,984,181 төг
3.	<u>Зам хоног:</u> 2 хүн x 60\$ x 9 хоног = 1080\$ x 2,849.61 = 3,077,578,8 төг	3,077,578.8 төг
4.	<u>Хот доторхи унааны зардал</u> 2 хүн x 10\$ x 7 хоног = 140\$ x 2,849.61= 398,945.4 төг	398,945.4 төг
5.	<u>Даатгал:</u> 2 хүн x 34,250 = 68,500 төг	68,500 төг
6.	<u>PCR шинжилгээ:</u> ОХУ-д 2 хүн x 1500 руб = 3000 руб x 38.67 =116,010 төг	116,010 төг
	ДҮН	14,951,275 төг

Жич:

- Монгол банкны 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн ханш: 1 ам.доллар = 2,849.61 төгрөг, 1руб = 38.67 руб